

БАТЛАВ
ЁС ЗҮЙН ХОРООНЫ АЖЛЫН
АЛБАНЫ ДАРГА
Н. ГАНБААТАР

**МОНГОЛ УЛСЫН ЁС ЗҮЙН ХОРООНЫ БЭЛГЭ ТЭМДЭГ /ЛОГО/
ШАЛГАРУУЛАХ БҮТЭЭЛИЙН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

- 1.1. Монгол Улсын Ёс зүйн хорооны үйл ажиллагааны чиглэлийг бүрэн илэрхийлсэн өгүүлэмжтэй, утга агуулгад нийцсэн бэлгэ тэмдгийг сонгон шалгаруулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

- 2.1. Иргэн, хуулийн этгээд, уран бүтээлчид оролцох.

Гурав. Бүтээлд тавигдах шаардлага

- 3.1. Ёс зүйн утга санааг бэлгэдсэн энгийн ойлгомжтой, өгүүлэмжтэй 5-аас илүүгүй элементийг агуулсан, 3-аас илүүгүй өнгө хосолсон цогц утга агуулгатай бүтээл байх;
- 3.2. Бүтээлийг график дизайны мэргэжлийн програм ашиглан хийгдсэн байх;
- 3.3. Бүтээл нь чөлөөт дүрс, хэмжээтэй, өндөр нягтралтай (600 dpi дээш) байх;
- 3.4. Жижгээс том руу хувиргахад харьцаа алдагдахгүй үндсэн элементүүд харагдаж байх;
- 3.5. Бүтээл нь хар, цагаан болон өнгөт гадаргуу дээр хэвлэгдэхээр зохиогдсон байх;
- 3.6. Уран бүтээлч өөрийн зохиосон хэдэн ч бүтээлээр оролцож болох бөгөөд бүтээл тус бүрийг тайлбарласан тайлбар, өнгөний кодыг хавсаргах.

Дөрөв. Бүтээл ирүүлэх

- 4.1. Эцэг/эхийн нэр, өөрийн нэр, холбоо барих утасны дугаар, ажлын болон оршин суугаа хаягийг тодорхой бичиж, бүтээлийг tiff, jpg, png өргөтгөлтэй файлаар форматаар 2024 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн 17:00 цаг хүртэл info@ec.gov.mn цахим хаягаар ирүүлэх.

Тав. Сонгон шалгаруулах

- 5.1. Тайлбаргүй бүтээлд сонгон шалгаруулалт хийх боломжгүй.
- 5.2. Бүтээлийг хүлээн авч дууснаас хойш ажлын 15 хоногийн дотор Монгол Улсын Ёс зүйн хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, сонгон шалгаруулна.
- 5.3. Сонгон шалгаруулсан бүтээл нь Монгол Улсын Ёс зүйн хорооны өмч болно.

Зургаа. Урамшуулал

- 6.1. Нэг бүтээлийг сонгон шалгаруулж батламж, 2,000,000 төгрөгөөр урамшуулна. /Монгол Улсын хуулийн дагуу татвар суутгагдана./

Долоо. Бусад

- 7.1. Бүтээл нь сонгон шалгаруулалтын хуралдаанаар хэлэлцүүлэгдэн шалгараагүй тохиолдолд дахин зарлаж өмнөх бүтээлийг оролцогчдод буцаан олгоно.
- 7.2. Шалгарсан бүтээлийн эхийг график дизайны програм дээр (adobe photoshop (PSD), Corel Draw (CDR), Adobe Indesign (EPS), Adobe Illustrator (AI)) хүлээн авна.

Утас: +976- 51-266021

Цахим хуудас: www.ec.gov.mn
Цахим шуудан: info@ec.gov.mn

Ажлын алба